МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 16 өдөр Дугаар А/80 Мөрөн сум

Ариутгал, халдваргүйтгэл, сэг зэм
устгалын ажил зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1 , Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2022 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн А/51 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хүн, малын гоц халдварт өвчний тархалтаас урьдчилан сэргийлж, отор нүүдэл, өвөлжилтийн хүндрэл, өвчний улмаас хорогдсон мал, амьтны сэг зэмийг устгах, бэлчээр, бууц, хашаа, байр, зоорь, агуулах, уст цэг, усны эх булгийг цэвэрлэх халдваргүйтгэлийн ажлыг 2022 оны 04 дугаар сарын 01-ний өдрөөс 05 дугаар сарын 20-ний өдрийн дотор аймгийн хэмжээнд зохион байгуулж, шаардлагатай хүн хүч, машин техник, шатахуун бусад зардлыг шийдвэрлэж ажиллахыг Мал эмнэлгийн газрын дарга (Л.Ариунаа), сумын Засаг дарга нарт тус тус даалгасугай.

2. Ариутгал халдваргүйтгэлийн ажлыг мэргэжил арга зүйн удирдлагаар ханган, холбогдох тайлан мэдээг 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэст ирүүлэхийг аймгийн Мал эмнэлгийн газрын дарга (Л.Ариунаа), ариутгал, халдваргүйтгэлийн ажлын явц, чанар гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн хяналтын газрын дарга (Д.Түмэнбаяр), хэрэгжилтийн тайлан мэдээг аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Б.Оюунтуяа) нарт тус тус даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д үүрэг болгосугай.

ДАРГА Ш.ИДЭРБАЯСГАЛАН